

**ЖУАНЗ**

/үргэлжлэл/

Ч.ТААМАА

МУИС, ГХСС, Хятад судлалын тэнхим

Жуанзын уг нэрийг Жуанжөү /МЭӨ 369-286 оны орчим /гэдэг бөгөөд Байлдаант улсын үеийн Сүн улсын Менда хэмээх /Өнөөгийн Шандунийн Цао гацаа/ газрын хүн юм. Тэрээр Менэтэй нэгэн үед амьдарч байжээ. Жуанз тухайн нутгийнхаа жижиг ноён байсан ба насаараа ядуу зүдүү амьдарсан ч аугаа их сэтгэгч байж, Лаозын дарзаа ордог Даоизмын нэг нэрт төлөөлөгч болсон юм. Тиймээс хожмын хүмүүс Жуанз болон Лаозын, Даосизмын үзлийг нэгтгэн Лao Жуаны гүн ухаан хэмээн нэрлэх ёс бий. Жуанзын үзэл санаа "Жуанз" номонд багтсан байдаг.

Жуанзын үзэл санаа үндсэндээ Лаозын үзэл баримтлалтай гарал үүсэл нэгтэй ч зарим нэг ялгаа байдаг. Лаоз: ертөнц дээр том жижиг, өндөр нам зэрэг ялгаа, сайхан муухай, сайн муу зэрэг эсрэг тэсрэг талууд бий гэж үздэг байсан бол Жуанз эдгээр ялгаа болон эсрэгцлийг бүхэлд нь үгүйсгэжээ. Харин дэлхий дээр үнэн худал гэсэн ялгаа байхгүй гэж хэлэхэд болно хэмээн үзсэн. Тухайлбал сармагчин модон дээр амьдрахыг тааламжтай гэж боддог бол хүн үүнийг их аюултай гэж үздэг. Мөн эсрэгээр хүн байшинд амьдрахыг тааламжтай гэж үздэг ч сармагчинг байшинд хоривол тэсэхийн аргагүй санагдана. Өөр нэг жишээ гэвэл: анхилам, өмхий гэдгийн тухайд нохой баас идэхдээ анхилам гэж боддог бол, хүнд энэ нь харин их өмхий санагддаг. Иймээс бүх зүйл өөрийн гэсэн сайнтай муутай, болох болохгүйтэй байдаг ба үнэн худлыг зааглах ямар ч шалгуур байдаггүй. Өөрөөр хэлбэл, үнэн харьцангуй шинжтэй хэмээн тэрээр үзсэн буй.

Жуанз "Дао"-д өөрт нь хил хязгаар үгүй бөгөөд хил хязгаар нь зохиомол, мөн ялгаа зөрүү ч зохиомол юм гэж үзжээ. Учир нь ялгаа зөрүү, хил хязгаар гэж байж л үнэн худал, сайхан муухай, эрхэм дорд гэж байх болно. Хэн бүхэн өөрийн зөв, бусдын буруу гэж батлахыг хүсдэгээс янз бүрийн тэмцэл бий болдог. Бодит байдал дээр юмс бүгд ижил бөгөөд задлан шинжлэхүй, танин мэдэхүй, оролцохгүй, бүхнийг мартах, хий хоосон хил заагийн дотор хөгжиж, хий хоосон хил хязгаарын дотор өөрийгөө л болгох нь хамгийн зөв юм.

Жуанз дэлхий ертөнцийг зохиомол, тэмцлээр дүүрэн урьдчилан таамаглахын аргагүй гэж үзээд, хүн дэлхий дээр амьдрах нь буудлагын

талбай дээр байхтай адил тул яаж ч харвасан суманд оногдохгүй байх билээ? Нуугдан зайлах аргыг л ашиглах боломжтой. Үүнд: 1-р т, хэрэгтэй хүн болохгүй, давалгааны дагуу алгуур урсах хэрэгтэй. Тухайлбал: Мод өндөр ургах тусам хүний гарг өртдөг., энэ нь хэрэгтэйгээсээ болж байгаа юм. Хэрэв жижигхэн бол хэрэггүй тул өөрийн амийг хамгаалж дөнгөх билээ. 2-р т, "Би үгүй" байх. Энэ нь өөрийгөө мартаж, аливаа бүхнээс ангижрах гэсэн үг юм. "Би үгүй" байх аргыг эзэмшвэл гадны аливаа өдөөн хатгалга, уруу таталтын нөлөөнд автахгүй, юунд ч сэтгэл үл хууртан, юуг ч ойшоохгүй болж, бүр цаашлаад өөрийн оршин буйгаа ч мартана. Хэрвээ энэ хязгаарт хүрч чадвал эх байгаль дэлхийтэйгээ нэгэн цогц болон уусч хүний амьдралын хамгийн дээд эрх чөлөөг эдлэх болно.

Ерөнхийдөө Жуанз болон Лаозын үндсэн үзэл баримтлал, амьдрах ухааны философи нь адил юм. Ухаандаа зүй тогтлын дагуу хувь заяандаа сэтгэл ханах, бодит байдлаас зайлсхийж, тайвнаар жам ёсыг дагах явдал юм. Ийм туйлын хийсвэрлэсэн, идэвхигүй, ертөнцөөс тасарсан даосизмын үзэл санаа нь идэвхитэй амьдралд оролцохыг гол болгон баримталдаг Кунзийн сургаалыг баримтлагсдын үзэл санаанаас тэс өөр бөгөөд Даосизмын үзэл санаа нь азгүй, гутранги байр сууринд байдаг хүмүүст амархан хүрч, тэдний оюун санааны амин сүнс болдог.

Иймээс нийгэм эмх замбараагүй, төр засаг харалган, тайван амгалан бус цагт Лао - Жуаны үзэл санаа нь ихэд тархдаг. Лао - Жуаны үзэл санаа нь нэг талаас идеалист, хуучинсаг, идэвхигүй ч нөгөө талаас маш үнэ цэнэтэй философиин үзэл бодлоор дүүрэн юм. Тухайлбал: Дэлхий нь орчил хөдөлгөөн, хувирал өөрчлөлтөнд оршдог, юмс үзэгдлийн ялгаа нь харьцангуй эсрэг тэсрэгийн тал харилцан солбицож байдаг гэж үздэг байжээ. Тиймээс Лао Жуаны үзэл санаа Кунзийн сургаал, хуулийн сургаалийн адил Хятадын эртний сэтгэлгээний соёлын үнэтэй өв болдог.

### Даосизмын сургаалын хувь заяа

Даосизмын урсгалыг хавар намрын үед Лаоз бий болгосон ба даосизм байлдаант улсын үед төлөвшин, тухайн үеийн "100 сургаалтны өрсөлдөөн" доторх нэгэн сургаал болж Кунзийн сургаалын эсрэг чиглэж байжээ. Цинши хуанди хаан Хятадыг нэгтгэснийхээ дараа хуулийн сургаал голлон тулгуурлаж байсан тул даосизмын сургаал, Кунзийн сургааль нэгэн зэрэг шахагдан хавчигдаж, даосизмын сургааг нэгэн урсгал болж оршин

## МУИС Нийгмийн Шинжлэх Ухааны Сургууль

тогтохоо болжээ. Гэвч Хан улсын эхэн үед даосизмын үзэл санаа дахин дэлгэрчээ. Гол шалтгаан нь Хан улсын Гаозу хаан Лиүбан зарим түшмэдийнхээ “Зөнгөөр нь төр засах” санааг хүлээн авч, Цин улсын мөхлийн шалтгааныг хаан эзэн нь хэт хүчирхэг болохыг тэмүүлэн хүсч, хууль зарлиг дэндүү олширч, ял шийтгэл дэндүү харгис хэрцгий болсноор үр дүн нь уруугаа эргэсэн гэж үзжээ. Харин “Зөнгөөр нь байлгах” үзэл бол төрийг засах хамгийн сайн зарчим юм хэмээгээд, даосизмын үзэл санааг эрхэмлэж үзжээ.

Лиүбан үхсэний дараа Цао Цан чансан болж, зөнгөөр нь байлгах төрийн бодлогыг тууштай хэрэгжүүлж, хаан эznээсээ эхлэн арвилан хэмнэж, ард түмний албан татварыг багасган, ял шийтгэлийг хөнгөрүүлснээр эдийн засаг хөгжиж, даосизмын үзэл санаа үнэхээр үр дүнгээ өгсөн байна. Гэвч зарим нэг сөрөг талыг бий болгосон, тухайлбал, хүмүүс дээд доод, эрхэм дордын дэг жаягыг хайхрахаа болж сайд, ноёдын нөлөө эрхшээлээ нэмэгдүүлж байв. Иймээс Хан улсын Уди хааны үед дахин Кунзийн үзэл санааг ашиглан төр засгийг бэхжүүлж, улс гүрнээ төвхнүүлэхийг оролдож “Зуун сургаалыг таягдан хаяж, зөвхөн Кунзийн эрдмийг шүтэх” төрийн бодлогыг хэрэгжүүлжээ.

Ингэснээр даосист үзэл санааны алтан үе дуусчээ. Гэвч зүүн Хан улсаас хойш Вэй, Жин, Өмнөд, умардын улсуудын дараа Сүй, Тангийн үе болоход Кунз, Дао 2 сургаал дээр Энэтхэгээс орж ирсэн бурхны сургаал нэмэгдэн, аажимдаа 3 сургаал зэрэгцэн оршиж эхэлсэн. Даосизмын үзэл санаанд мандан бадрах, доройтон балрах, овоо товон үеүд байсан хэдий ч хэзээ ч бие даан орших байр сууринд хүрээгүй ба зөвхөн Кунзийн үзэл санааг нөхвөрлөн оршиж байсан юм.

Зүүн Ханы үед төр засаг улам доройтсныг зарим хүмүүс Кунзийн үзэл санаатай холбон үзэж, даосизмын үзэл санааг дахин сэргээн дэлгэрүүлж, нийгмийн хямралаас гаргахыг оролджээ. Тухайн үед нийгэмд “Энх Шашин” хэмээх бумбын шашны байгууллага гарч ирэн “Энх судар” хэмээх номыг баримтлах болжээ. “Энх судар” нь “Төрийг засах зүй”-г шинжлэн судалсан байдаг ч далд нууцлаг сүсэг бишрэлийн өнгө аясаар дүүрэн, Лаозыг сахиус болгон “Дээд Лао хаан” хэмээн нэрийдэж, хүмүүсийг шүтэхийг шаардсан байдаг ажээ. Зүүн Ханы хожуу үед Жан жяогийн удирдсан тариачны бослого ч бас тэмцэлдээ “энхийн судар”-ыг ухуулан сурталчилж, Лаозыг шүтэн, бумбын шашны туг тэмдэгийг дээдлэн тахиж өйжээ. Гэвч шинээр сэргэн мандсан бумбын шашин, Зүүн Ханы хожуу үеийн доройтон ялагдах хувь заяаг авраагүй ба Жан жяогийн, Шар алчууртны бослого ч ялагдсан юм.

Вэй, Жин, Өмнөд, Умардын улсуудын үед бурхны болон бумбын шашин шүтэх нь олширч, хүмүүс даосист үзэл санааны төрийг засч ертөнцийг аврах ёсыг үндсэнд нь өөрчилж, урт насалж, үл көгшрөн, хувилгаан болгон хөгжүүлэх үзэл болгохыг эрэлхийлснээр Лаоз, Жуанзын үндсэн үзлээс улам бүр холджээ. Үүнээс хойш бумбын шашин Хятадын их шашин болж, маш олон урсгалууд үүсч гадаадад ч дэлгэрчээ. Иймээс Даосист шашин болон Даосист философи нь хоорондоо холбоотой ч ńэгэн ижил зүйл огт биш тул тэдгээрийг хольж хутгаж болохгүй.

Zhong guo gai Kuang. Beijing. 1995,  
номоос орчуулга хийв.